



СТЕП ГОЛД ХХК

БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Степ Голд ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Ёс зүйн дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн зорилго нь хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, компанийн удирдах албан тушаалтан, нийт ажилчдын үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоох, төлөвшүүлэх, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино. Компани үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг баримтална. Үүнд: хүний эрхийг эрхэмлэх; хууль дээдлэх; шударгаар ажиллах; ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, бусдад ялгаваралгүй хандах зэрэг орно

1. Ерөнхий зарчим

Степ нь өөрийн бизнес, үйл ажиллагааг ёс зүйн дээд зэргийн жишиг болон хуулийн дагуу, шударга, нэгдмэл байдлаар явуулах үүрэг хүлээсэн.

Энэхүү дүрмийг дор дурдсан этгээдүүд дагаж мөрдөнө. Үүнд: Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, тэдгээрийн дарга, гишүүд, удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан; Компанийн бүх газар, хэлтэс, нэгжийн хариуцсан болон дэд захирал, захирал, менежер, ахлах ажилтан; Компанитай Хөдөлмөрийн болон Контрактын гэрээ байгуулан ажиллаж байгаа бүх ажилтан, албан хаагч; Компанитай Ажил гүйцэтгэх гэрээ болон Хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж буй иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн төлөөлөл; Компанийн туслан гүйцэтгэгч, түүний удирдах албан тушаалтан; Бүх удирдах ажилтнууд Ёс зүйн дүрмийн заалт, шаардлагуудтай танилцаж өөрийн удирдлага дор ажиллаж буй ажиллагсдад өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажиллуулж, түүнд байнга хяналт тавина.

Энэ дүрэм нь дээрх бүхий л төлөөлөгчдөд чиглэсэн Компанийн зүгээс баримтлах бизнесийн ерөнхий зарчим, чиглэл болох бөгөөд уг дүрмийг Компанийн баталсан одоо хэрэгжиж буй бусад дүрэм журам болон Компанийн зүгээс цаашид шинэчлэн батлах бусад бодлогууд дагалдана.

2. Дүрмийн хэрэглээ

Энэхүү Дүрмийг нийт Төлөөлөгчид мөрдөх бөгөөд энэ Дүрмийн хамгийн сүүлийн хувилбарыг хүлээн авснаар таныг дүрмийн нөхцлийг хүлээн зөвшөөрч, даган мөрдөхөө илэрхийлж байна гэж үзнэ.

3. Дүрмийг танилцуулах нь

Энэхүү Дүрмийн хуулбарыг бизнесийн хамааралтай бүх этгээдүүдэд, шууд эсвэл Компанийн веб хуудас www.steppegold.com дээр байрлуулж танилцуулна. Шинэчлэсэн дүрмийг дээрх бүхий л төлөөлөгчдөд тухай бүр танилцуулна. Шинээр бизнесийн үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр хамтарч байгаа бүхий Төлөөлөгч нарт Дүрмийг танилцуулан баталгаажуулна.

4. Хуулийг даган мөрдөх нь

Компани өөрийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагаа явуулж буй харъяа нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж буй бүхий л хууль, дүрэм, журам, хөрөнгийн биржийн журам болон үнэт

цаасны журмын дагуу явуулна. Үүний хүрээнд, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүхий л монополийн эсрэг/өрсөлдөөний, нууцлалын, хөдөлмөрийн, хүний эрхийн, байгаль орчны болон үнэт цаасны тухай хууль тогтоомжийг даган мөрдөнө. Монгол Улсын хууль тогтоомж, Компаниас гаргасан дүрэм, журамд заасан болон Компанитай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлж, хариуцсан ажилдаа идэвхи санаачлагатай үр чадвараа дайчлан ажиллана.

Компанийн удирдлага үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахдаа хууль тогтоомж, дүрэм журмыг удирдлага болгон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандана. Компанийн ажилтнууд хамт олны дунд биеэ зөв авч явах, нийтээр даган мөрддөг ёс суртахууны хэм хэмжээг мөрдөх, бусдыг хууль бус ажиллагаанд өдөөн түрхирах, хамт олны дунд хэрүүл тэмцэл маргаан үүсгэхийг хатуу хориглоно. Компанийн ажилтнууд ажлын байр болон өөрийн ахуй амьдралд хамаарах асуудлаар хууль зүйн мэдлэг болон ажлын үр чадвараа тогтмол хөгжүүлж, шударгаар хөдөлмөрлөнө.

Компанийн удирдлага болон ажилтнууд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд ямагт хүндэтгэлтэй хандаж, хуулиар олгогдсон үүргээ сахин биелүүлж, эрхээ баталгаатай эдэлнэ.

5. Хууль бус үйлдлийг мэдэгдэх нь

Степ нь бизнесийн орчинд нэгдмэл байдлыг дэмжиж, хууль бус үйлдлийн эсрэг орчныг бий болгохыг зорьж ажилладаг. Компанитай холбогдох бүхий л санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг үнэн зөв бодитоор хангуулах, энэхүү Дүрэмд заасан удирдамж, чиглэлийг даган мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүргийг Зөвлөл хүлээнэ.

Хэрэв дээрхтэй холбоотой аливаа санал, гомдол, асуудлыг Компанийн веб хуудас www.steppegold.com дээр байгаа Компанийн Мэдээлэх Бодлогод дурдсан журмын дагуу мэдээлнэ. Мэдээлэх Бодлогоор Компанитай холбоотой аливаа хууль бус үйлдэл, эргэлзээтэй нягтлан бодох бүртгэл, санхүүгийн дотоод хяналт болон дотоод аудиттай холбоотой асуудлаар нууц, нэргүй мэдээлэл хийх боломжийг олгодог.

6. Дүрмийг даган мөрдөх тухай баталгаа

Компанийн бүх захирал, албан тушаалтан нар нь Зөвлөлөөс тодорхойлсон бүхий л ажилтан, зөвлөх, гүйцэтгэгч нарын хамт өөрсдийн ажил үүргээ гүйцэтгэж байгаа болон Степийн бизнесийн үйл ажиллагаагаа явуулж байгаа харъяа нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүхий л хууль тогтоомж, дүрэм журмыг даган мөрдөж байгаагаа баталгаажуулан, энэхүү Дүрмийг даган мөрдөх тухай баталгааг гарган өгнө.

Компанийн Гүйцэтгэх захирал компанийн бүх захирлууд, ажилтнууд, нэр заасан зөвлөхүүд болон гүйцэтгэгч нараас жил бүрийн санхүүгийн хамгийн эхний улирлын эцэст эсвэл түүнээс өмнө Даган мөрдөх тухай баталгааг хүлээн авч, тэдгээр баталгаануудыг хүлээн авсан тухай баталгаажуулах мэдэгдлийг бичгээр гарган, үр дүнг нь нэгтгэж Зөвлөлд хүлээлгэн өгөх ажлыг хариуцна. Дүрмийг даган мөрдүүлэх үүднээс, тухайн нөхцөлд тохирох байдлаар нь, энэхүү Дүрмийн нөхцлүүд болон Степээс гаргасан компанитай холбоотой бусад бодлогуудын талаарх үнэн зөв бүрэн ойлголттой болоход нь Төлөөлөгчдөд туслахын тулд сургалт явуулж болно.

7. Мэргэжлийн ёс зүйн стандартууд

Степ нь өөрийн бизнесийн нэр хүндийг ямагт ёс зүйн өндөр хэм хэмжээнд байлгахыг зорилгоо болгодог, Компанийн бүхий л үйл ажиллагаа нь нийтэд ил тод байхыг бодолцож, үйл ажиллагаагаа ёс зүйтэй, шударга нэгдмэл байдлаар хэрэгжүүлнэ. Степийн бүхий л төлөөлөгч нар дээрхийг мөрдлөг болгох, ийн хэрэгжүүлээгүй аливаа үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд ажил үүргийн ноцтой зөрчил гэж үзнэ.

8. Хөрөнгийг хамгаалах ба зохистой ашиглах нь

Бүх төлөөлөгчид компанийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээ, мэдээлэл (нууцлалын зэрэгтэй болон бусад), тэмдэглэл, материал, ажлын байр, тоног төхөөрөмж гэх мэт Компанийн эд хөрөнгөнд зохистой хандаж, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлыг харгалзан үзэх ёстой. Компанийн хөрөнгийг хувийн ашиг орлого, ашиг тусын тулд ашиглахгүй. Мөн түүнчлэн, бүх Төлөөлөгчид эдгээр хөрөнгийг аливаа алдагдал, хохирол, зүй бус ашиглалт, хулгай, үргүй зарцуулалтаас хамгаалах ёстой бөгөөд эдгээр хөрөнгийг зөвхөн хууль ёсны хүлээн зөвшөөрөгдсөн бизнесийн зорилгоор ашиглана.

9. Нууцлал

Мэдээлэл нь компанийн гол өмч юм. Энэ нь компанийн Нууцлалын Бодлогод дурдсанаар, компанийн зүгээс бусдад итгэмжлэн задруулсан өмчлөлийн болон нууцлалын мэдээлэл гэх зэргээр эдгээрийг дээд зэргээр нууцлах бодлогыг Степ хэрэгжүүлдэг. Хувь хүн, байгууллагын нууцыг чандлан хадгалах бөгөөд бизнесийн нууцыг бусдад задруулахгүй. Компанийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээ, мэдээлэл (нууцлалын зэрэгтэй болон бусад), тэмдэглэл, материал, ажлын байр, тоног төхөөрөмж нь нууцлалд хамаарна. Компанийн бизнес, бизнесийн боломжууд, эд хөрөнгө, нийлүүлэгч, өрсөлдөгчдийн талаарх нууцлалын зэрэгтэй бүхий л мэдээллийг санаатай болон санамсаргүйгээр задруулахыг хориглоно.

10. Хувийн мэдээлэл

Компанийг төлөөлөн ажиллахдаа бусад ажилчид болон гуравдагч этгээдэдээс хувийн мэдээллийг нь хүлээн авсан ажилчид тэдгээр мэдээлэл авахдаа хуулийн хүрээнд, ёс зүйн хэм хэмжээг баримтлан, тулган шаардсан байдал гаргалгүйгээр гүйцэтгэх ёстой бөгөөд мэдээллийг ямар зорилгоор авах гэж байгаагаа хувь хүнд урьдчилан танилцуулах ёстой. Хувийн бүхий л мэдээллийг зохистой байдлаар авч, шаардлагатай хугацаанаас хэтрэлгүйгээр хадгалахын тулд ажилчид шаардлагатай бүх арга хэмжээг авна. Компанийн эзэмшилд байгаа бүхий л хувийн мэдээллийн нууцлалыг бүх ажилчид дээд зэргээр хангах ёстой. Ажил үүргээ гүйцэтгэхэд нь зохих үндэслэлтэйгээр шаардаагүй л бол ажилчид хувийн мэдээллийг бусад ажилчдад задруулах ёсгүй. Мөн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн хүрээнд ийн задруулахыг шаардаагүй, мөн холбогдох хувь хүнээс зохих зөвшөөрөл аваагүй л бол ажилчид хүний хувийн мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд задруулах ёсгүй.

11. Шударгаар ажиллах нь

Степ, түүний үнэт цаас эзэмшигчид, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид, өрсөлдөгчид болон ажилчидыг төлөөлөн гүйцэтгэх бүхий л бизнес, ажил хэргийг Компанийн үйл ажиллагааны нэгдмэл байдал, нэр хүндийг хамгаалахуйц хэлбэрээр явуулна. Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчид, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид, өрсөлдөгчид болон ажилчидтай харилцахдаа бодит баримтыг буруу илэрхийлэх, арга заль хэрэглэх, нуун төөрөгдүүлэх, нууцлалын мэдээллийг

урвуулан ашиглах болон бусад аливаа хууль бус, шударга бус үйлдэл гаргахаас сэргийлэх бодлого баримтална.

12. Сайн төлөөлөл

Бүх Төлөөлөгчид өөрсдийн ажил болон хувийн амьдралдаа Степийг төлөөлж байдаг. Төлөөлөгчдийн ажлын бус цагаар өөрсдийн амьдралаа зохицуулах боломжийг Компанийн зүгээс дэмжихийн зэрэгцээ, Төлөөлөгчдөд өөрсдийн сайн нэр хүндийг төдийгүй Компанийн нэр хүндийг унагалгүйгээр биеээ зохистой авч явахад нь зохих дэмжлэг үзүүлдэг.

Бүх Төлөөлөгчид Степийг мэргэжлийн түвшинд төлөөлнө. Компанийн нэр хүнд, имижид хэдийд ч хохирол эрсдэл учруулж болохгүй. Төлөөлөгчдийн бие авч яваа байдал компанийг илэрхийлэх учраас, бүхий л үйлдэлдээ Компанийн бодлогуудын шаардлагыг анхаарч тусгах ёстой.

13. Ашиг сонирхлын зөрчил

Одоо хамтран ажиллаж байгаа болон цаашид хамтран ажиллах бизнесийн түншүүд, бусад төлөөлөгчидтэй хийх бүхий л үйл ажиллагаанд Компанийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж, ашиг сонирхлын бодит хийгээд болзошгүй зөрчил гарахаас сэргийлэн ажиллах бодлогыг Степ баримталдаг. Бусдад авлига, хээл хахууль өгөх, авах, зуучлахыг хориглоно. Бусдад шан харамж өгөх, авах, өгөхөөр амлах, зуучлахыг хориглоно. Бусдаас хууль бус шийдвэр гаргуулахаар нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэх, зүй бусаар нөлөөлөхийг хориглоно. Авлигын тохиолдлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлнэ. Ажил үүрэгтэй холбоотойгоор сонирхлын зөрчилдөөн бий болох нөхцөл үүсвэл уг ажил, үйлчилгээг хийхээс шууд татгалзана. Сонирхлын зөрчлийн улмаас холбогдогч аль нэг талд давуу байдал үүсгэхгүй байна. Компанийн эд хөрөнгө, эд зүйлсэд ариг гамтай хандаж, өмч хөрөнгийг зөвхөн компанийн үйл ажиллагаанд хэрэглэнэ.

Бусдын хувийн онцлог, зан байдалд хүндэтгэлтэй хандаж, хэнийг ч үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүй. Ажилтныг байгаагаар нь хүлээн авах, хувийн онцлогынх нь хувьд зайлшгүй шаардлагатайгаас бусад нөхцөлд өөрчлөх, засахыг үл эрмэлзэнэ. Хувийн ашиг сонирхлыг компанид халдааж болохгүй.

Компанид ажиллаж байгаа хэн боловч ажил хэргийн хамааралтай, эсвэл хамааралтай болж болох аливаа этгээдээс санхүүгийн туслалцаа, тусгай хөнгөлөлт, зээл тусламж хүсэх, хүлээн авахыг хориглоно. Ажил үүргээ биелүүлэхдээ шударгаар, чин сэтгэлээсээ компанийн ашиг сонирхлын төлөө ажиллана. Хувийн, гэр бүлийн эсвэл бизнесийн ашиг сонирхол нь компанийн ашиг сонирхолтой зөрчилдөх аливаа нөхцөл байдал үүсэхээс сэргийлж, ашиг сонирхлын зөрчил үүсвэл компанид нэн даруй мэдэгдэнэ. Ашиг сонирхлын зөрчилтэй асуудалд санал өгөхөөс татгалзах үүрэгтэй. Ашиг сонирхлын зөрчлийн улмаас санал өгөх боломжгүй болсон, эсвэл түүний хувийн, бизнесийн болон мэргэжлийн ашиг сонирхолд нөлөөлөх аливаа асуудлыг хэлэлцэх хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах ажиллагаанд оролцохгүй. Компанийн өмч хөрөнгө, мэдээлэл, албан тушаалыг хувьдаа ашиглаж, давуу тал бий болгохыг хориглоно. Компанитай шууд болон шууд бусаар өрсөлдөхийг хориглоно.

Захирлууд бүхий л бодит болон болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх хууль ёсны үүрэг хариуцлага хүлээхээс гадна, тухайн захирал ашиг сонирхлын зөрчилтэй байх аливаа асуудалд санал өгөхөөс татгалзах үүрэгтэй. Ашиг сонирхлын зөрчлийн улмаас санал өгөх боломжгүй

болсон, эсвэл түүний хувийн, бизнесийн болон мэргэжлийн ашиг сонирхолд нөлөөлөх аливаа асуудлыг хэлэлцэх хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах ажиллагаанд тухайн захирал оролцохгүй.

14. Компанийн боломжууд

Төлөөлөгчдийн хувьд корпорацийн өмч хөрөнгө, мэдээлэл, албан тушаалыг ашиглах, корпорацийн өмч хөрөнгө, хувийн мэдээлэл, албан тушаалыг ашиглах замаар үүсч болох аливаа давуу тал, боломжийг өөрсдөө эдлэх хориотой. Төлөөлөгчдийг мөн Стептэй шууд болон шууд бусаар өрсөлдөхийг хориглодог ба төлөөлөгчид Компанийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах шаардлагатай нөхцөл үүсвэл Стептийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүрэг хүлээнэ.

15. Эрүүл мэнд ба аюулгүй байдал

Компани нь эрүүл аюулгүй, үр өгөөжтэй ажлын орчинг бий болгох аюул осолгүй ажлын түршлагыг нэвтрүүлэхийг ямагт эрмэлздэг. Ажилтнууд, төлөөлөгчид өдөр тутмын үйл ажиллагаандаа компанийн зүгээс баталсан хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Ажлын байранд аюулгүй байдлыг ханган ажиллах, ажлын байрны ослыг хамгийн бага хэмжээнд байлгах үүднээс аюултай нөхцөлийг нэн даруй холбогдох шууд удирдлагад мэдээлж зохих арга хэмжээг авах үүрэгтэй.

Бүх ажилчдын аюулгүй байдлыг сахин хамгаалахын тулд өөрийн хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд саад болох аливаа сөрөг нөлөөнөөс ангид байхаас гадна ажлын байранд анхаарал болгоомжтой байж, согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэхийг хатуу хориглоно.

16. Цахим хаяг болон интернэт үйлчилгээний хэрэглээ

Ажлын байранд цахим хаяг болон интернэт сүлжээг хувьдаа ашиг олох эсвэл зохисгүй зорилгын төлөө ашиглахыг хориглоно. Бэлгийн дарамт үзүүлсэн материал, ёс бус үг хэллэг, үндэс угсаа, арьсны өнгөөр гутаан доромжилсон аливаа дарамт, доромжлол, хүчирхийллийн шинжтэй мэдээ, мэдээлэлд нэвтрэх, үзэх, илгээх, татаж авах, тараахыг хориглоно. Сурталчилгааны мэдээлэл, хэрэгцээгүй мэдээ, ажил үүрэгт хамааралгүй цахим шуудан зэргээр Компанийн мэдээллийн системийг дүүргэхийг хориглоно.

Зохиогчийн эрхтэй материалыг татаж авах, хэрэглэхийг нь тусгай зөвшөөрлөөр зөвшөөрөөгүй материалыг хуулбарлан авахыг хориглоно. Компаниас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр тусгай зөвшөөрлөөр хэрэглэж буй материалд өөрчлөлт оруулж болохгүй. Тоглоом, дэлгэц амраагч зэрэг вирусийн эх үүсвэр бүхий программ татаж авахыг хориглоно. Компани хуулиар хориглоогүй мэдээлэлд нэвтрэх, ил болгох эрхтэй. Цахим хэрэглээг зохисгүй байдлаар хэрэглэх, задруулж болохгүй мэдээ, мэдээлэл рүү нэвтрэх, илгээх, хадгалахыг хориглоно.

17. Улс төрийн үйл ажиллагаа ба хандив

Компани дээр гүйцэтгэх ажлын цагт нөлөөлөхгүй л бол ажилчид улс төрийн үйл ажиллагаанд оролцож болно. Ажлын байранд компанийн утас, компьютер, бусад хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэрийг ашиглаж улс төрийн шинжтэй аливаа үйл ажиллагаа сурталчлах, зохион байгуулахыг хориглоно.

Компанийн нэрийн өмнөөс улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчид санхүү, мөнгөн тусламж үзүүлэх, аливаа төрлийн хандив, дэмжлэг өгөхийг хориглоно. Дээд шатны удирдлагаас зөвшөөрөл аваагүй бол ямар ч ажилтан Компанийн нэрийн өмнөөс улс төрийн хандив өгч, амлаж болохгүй.

Компани мөн хандив өгөх нь хууль ёсны хийгээд уламжлал болсон газарт зөвхөн зөвшөөрсөн хэм хэмжээний дагуу улс төрийн намууд болон нэр дэвшигчдэд хандив өгч болно.

18. Бэлэг ба үзвэр үйлчилгээ

Бизнесийн зорилгоор бэлэг өгөх, үзвэр үйлчилгээ санал болгох нь бизнесийн хамтрагчдын дунд сайн харилцаа үүсгэх тогтсон хүндэтгэлийн илэрхийлэл юм. Эдгээр хүндэтгэл, найрсаг зангийн илэрхийлэлд хоол, үүх юмаар дайлах, спорт, урлагийн арга хэмжээний тасалбар, олон нийтэд санал болгодоггүй бусад хөнгөлөлтүүд, аялал, байр сууц болон бусад бараа таваар үйлчилгээ орно. Зарим улс орны соёлд эдгээр нь бизнесийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ, ийм хүндэтгэл, найрсаг зангийн илэрхийлэл нь – бидний бодитой, шударга бизнесийн шийдвэр гаргах боломжинд тохиролцоо хийсэн – эсвэл тохиролцоо хийх шинжтэй харагдаж байвал асуудал үүснэ.

Бизнесийн харилцаанд шударга бусаар нөлөөлж болзошгүй аливаа төрлийн бэлэг, шан харамж, үзвэр үйлчилгээг санал болгох, шаардах, хүлээн авахыг хориглоно. Эдгээр зарчим нь хэдийд ч байнга хэрэгжих бөгөөд уламжлалт бэлэг-өгдөг улирлуудад ч мөн адил өөрчлөгдөхгүй. (1) Өгч буй бэлэг нь бэлэн мөнгө биш, (2) уламжлал болсон бизнесийн зарчимтай нийцэж байгаа, (3) үнэ өртгийн хувьд хэт өндөр биш, (4) авилга, хээл хахууль гэж ойлгогдохооргүй, (5) хүчин төгөлдөр хэрэгжиж буй аливаа хууль, тогтоомжийг зөрчөөгүй, (6) Компанийн авилга хээл хахуулийн эсрэг бодлоготой зөрчилдөөгүй бол Компанийн аль нэг Төлөөлөгч, эсвэл Төлөөлөгчийн гэр бүлийн аль нэг гишүүн ямар ч бэлэг, үзвэр үйлчилгээг санал болгох ёсгүй, өгөхгүй, авахгүй, мөн хүлээн зөвшөөрөхгүй байх ёстой. Хэрэв та тохиромжтой эсэхийг нь мэдэхгүй байвал ямар нэгэн бэлэг, төлөвлөж буй бэлгийн талаар даргатайгаа зөвлөлдөөрэй.

19. Гутаан доромжлох

Бүх ажилчид төлөөлөгчид бусдыг гутаан доромжлох, айлган сүрдүүлэх, дайсагнах, доромжилсон аливаа тааламжгүй харилцаа, хандлага гаргахыг хориглоно.

Арьс өнгө, нас хүйс, гэр бүлийн байдал, гарал үүсэл, шашин шүтлэг, итгэл үнэмшил, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээлтэй байдал, эсвэл хуулиар хамгаалагддаг бусад хувийн шинж чанарт үндэслэн ялгаварлан гадуурхах, айлган сүрдүүлэх, дарамт үзүүлэхийг хориглоно. Аливаа хэлбэрийн дарамт, доромжлолоос ангид байна. Хамтран ажиллагчийн бие авч яваа байдал нь тав түхгүй байдал үүсгэж байгаа үед ажилчид энэ талаар илэн далангүй ярьж, доромжлох үйлдэл гаргасан нөхцөлд энэ талаар мэдэгдэх үүрэгтэй.

Ажилд авах, албан тушаал ахих, сургалтад хамрагдах, аливаа давуу тал боломжийг эдлэх, цалин, тэтгэмж авах, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох зэрэг хөдөлмөрийн харилцааны аль ч хэлбэрт Компанид ялгаварлан гадуурхал байхыг хүлээн зөвшөөрөхгүй. Ажилтнууд хувийн хүндэтгэл, харилцан итгэлцэлийг хөхүүлэн дэмждэг орчинг бий болгож, дэмжих ёстой. Хамтран ажиллагчийн бие авч яваа байдал нь тэдэнд тав түхгүй байдал үүсгэж байгаа үед ажилчид энэ талаар илэн далангүй ярьж, доромжлох үйлдэл гаргасан нөхцөлд энэ талаар мэдэгдэх үүрэгтэй.

20. Архи, мансууруулах бодис

Архи согтууруулах ундаа, эмийг /жортой болон жоргүй/ зүй бусаар хэрэглэх, эсвэл аливаа хууль бус мансууруулах бодис хэрэглэх нь хөдөлмөрийн аюулгүй байдал болон гүйцэтгэлд сөргөөр нөлөөлдөг ба Компанийн ажлын байранд эдгээрийг бүрэн хориглодог Ажлын байранд архи согтууруулах ундаа, мансууруулах бодис, эмийг /жортой болон жоргүй/ зүй бусаар хэрэглэхийг хориглоно. Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн этгээдийг ажлын байранд нэвтрүүлэхгүй.

21. Энэхүү Дүрмийг зөрчсөнөөс үүдэн гарах үр дагавар

Дүрмийг дагаж мөрдөхгүй байх нь ноцтой зөрчилд тооцно. Компанийн ажилтан болон бусад ажилтанд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан холбогдох хууль тогтоомж, Компанийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ. Хэрэв зөрчил гаргасан үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол зохих журмын дагуу хууль хяналтын байгууллагад хандана.

22. Дүрмийн хэрэгжилтийг үнэлэх нь

Компанийн удирдлага болон Дотоод аудын хэлтэс нь Компанийн бизнес, үйл ажиллагааг ёс зүйн болон эрх зүйн хэм хэмжээний дагуу шударга, нэгдмэл байдлаар хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор жил бүр энэхүү Дүрмийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгнө.

23. Лавлах зүйлс

Хэрэв энэхүү Дүрмийг хэрхэн дагаж мөрдөх талаар асууж тодруулах зүйл байвал, Компанийн Гүйцэтгэх Захирал, Дотоод аудитын албаны даргатай холбогдоно уу.

24. Дүрмийг даган мөрдөхөөс чөлөөлөх тохиолдлууд

Энэхүү Дүрмийг даган мөрдөхөөс чөлөөлөгдөх хүсэлтийг Компанийн захирал эсвэл гүйцэтгэх албан тушаалтан гаргаж болох бөгөөд сайтар шалгаж нягтлаад тухайн хүсэлт тохиромжтой эсэхийг үнэлж дүгнээд олгож болно. Аливаа хүсэлтийн зөвшөөрлийг компанийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд өгч байгаа эсэхийг хянах үүргийг Компанийн засаглал ба Нэр дэвшүүлэх хорооны саналд үндэслэн зөвхөн Зөвлөлөөс холбогдох хууль, хөрөнгийн биржийн дүрэм журмын дагуу олгоно.

25. Дүрмийг нийтлэх нь

Энэхүү Дүрмийг Компанийн веб хуудас www.steppegold.com дээр нийтэлнэ.

Хамгийн сүүлд батласан огноо: 2017 оны 10 сарын 2

Баталсан: Компанийн засаглал ба Нэр дэвшүүлэх хороо

Төлөөлөн Удирдах Зөвлөл

ДАГАН МӨРДӨХ ТУХАЙ БАТАЛГАА

Миний бие Степ Голд ХХК /цаашид “Степ” компани/ -аас гаргасан дараах бодлогуудыг хүлээн авч уншиж танилцсан, сайтар ойлгосон болохоо үүгээр батлаж байна. Үүнд;

- **Бизнесийн ёс зүйн дүрэм;**
- **Компанийн Ил тод байдлын бодлого;**
- **Үнэт цаас арилжааны бодлого;**
- **Мэдээлэх бодлого;**
- **Авлига, хээл хахуультай тэмцэх бодлого;**

(хамтад нь “Бодлогууд” гэх).

Миний албан тушаал, хариуцлагын хүрээнд хамаарах Бодлогуудыг бүрэн ойлгож, даган мөрдөж, хэрэгжүүлэн ажиллах үүрэгтэй болохоо би үүгээр мэдэгдэж байна. Миний ажлын байр болон ажил үүргийг зохицуулах бодлогууд, дүрэм журмыг би чанд сахих ёстой болохоо сайтар ойлгож байна.

Би үүнийг миний ажил эрхлэлт болон томилгоог (ажилтнууд болон зөвлөхүүдийн хувьд) үргэлжлүүлэх нөхцөл хэмээн үзэж, энэхүү хариуцлагыг хүлээж байгаа ба бодлогуудыг зөрчих нь миний Степ дахь ажил эрхлэлт болон зөвлөх үйлчилгээний хэлэлцээрийг дуусгавар болгох үр дагавартайг хүлээн зөвшөөрч байна.

Миний бие компанийн өмнө хүлээсэн өөрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ компанийн үйл ажиллагаа явуулдаг бүхий л харъяа нутаг дэвсгэрийн хууль, тогтоомж, дүрэм журмыг чанд даган мөрдөж ажиллах болохоо үүгээр баталж байна.

(Бодлогуудтай зөрчилдөж болох аливаа нөхцөл байдлын талаар бичих бол энэ хуудасны арын нүүрийг ашиглана. Аль болох дэлгэрэнгүй тодорхой бичнэ үү.)

НЭР (ДАРМАЛААР)

ГАРЫН ҮСЭГ

АЛБАН ТУШААЛ / КОМПАНИ

ОГНОО